



Хэвлэлийн мэдээ
2022 оны 10-р сарын 12

Холбоо барих
9909-1557

АмЧам Монголын 10-р сарын ээлжит хурлаар 2023 оны Монгол Улсын эдийн засгийн сорилт, төлөв байдлын талаар хэлэлцүүлэг өрнүүлэв



УЛААНБААТАР, Монгол Улс – Монгол дахь Америкийн Худалдааны Танхим (“АмЧам Монгол”) 2022 оны 10 дугаар сарын 11-ний өдөр “Blue Sky” зочид буудлын хурлын танхимд “2023 онд Монгол Улс хөгжих үү, хоцрох уу?” сэдэвт 10 дугаар сарын уулзалтаа зохион байгууллаа.

10-р сарын уулзалтад олон улсын санхүүгийн байгууллагуудын суурин төлөөлөгчид, Монгол Банкны төлөөлөгчийн хамтаар оролцож, Монгол Улсын ирэх оны санхүүгийн төлөв байдал болон болзошгүй үр дагаварыг тодорхойлж хэлэлцүүлэг өрнүүлэв. Хэлэлцүүлэгт ЕСБХБ-ны Монгол дахь төлөөлөгч ноён Ханнес Такаш, Дэлхийн Банкны суурин төлөөлөгч ноён Андрей Михнев, Монгол Банкны Санхүүгийн зах зээлийн хэлтсийн захирал хатагтай О. Одгэрэл нар оролцож, Монгол дахь Америкийн худалдааны танхимын ТУЗ-ын дарга, ноён Жеймс Лиотта модераторын үүргийг гүйцэтгэв.

ЕСБХБ-ны Монгол дахь суурин төлөөлөгчийн газрын дарга Х. Такаш модераторын нээлтийн асуултад хариулахдаа 2023 онд эдийн засаг 7.0%-иар өснө гэж таамаглаж байгаагаа хэлсэн бол Дэлхийн Банкны суурин төлөөлөгч А.Михнев 5 гаруй хувиар өснө гэж харж байгаа гэв. Харин Монгол Банкны Санхүүгийн зах зээлийн хэлтсийн захирал О. Одгэрэл 2023 онд 3.0%, 2024 онд 4.4%-иар өснө гэж өөдрөгөөр төсөөлж байгаагаа илэрхийлэв.



Дэлхийн Банкны суурин төлөөлөгч Андрей Михнев Монгол Улсын эдийн засгийг 2022 онд 2.4 хувиар өснө хэмээн Дэлхийн банк таамаглаж байна гэлээ. Оны эхээр КОВИД цар тахал намжиж эхэлсэнтэй холбогдуулан 2022 онд эдийн засаг хурдацтай сэргэх хүлээлттэй байсан ч Европ дахь дайн олон сорилтуудыг дагуулж, улмаар өсөлтийн эрчийг сааруулсан тухай Андрей Михнев дурдаад, цаашид учирч болох энэ мэт аливаа хямрал, саад бэрхшээлийг даван гарах эдийн засгийн дархлааг бий болгоход

анхаарч, бодлогын шаардлагатай реформ, арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх нь нэн чухал болохыг онцолсон юм. Ноён Михнев хэлэхдээ “Монгол Улсын эдийн засгийн өсөлт 2023 онд 5 хувийг давж эрчимжих төлөвтэй байгаа бөгөөд үүнд уул уурхайн олборлолт нэмэгдэх, гадаад орчин сайжрах зэрэг хүчин зүйлс голлон нөлөөлөхөөр байна. Гэхдээ Украины эсрэг хийж буй Оросын дайн хүлээлтээс даамжрах, КОВИД-19 цар тахал үргэлжлэх, өндөр хөгжилтэй орнууд мөнгөний бодлогоо улам хурдтайгаар чангаруулах зэргээс гадна дэлхий дахинд хүнс, эрчим хүчний хямрал нүүрлэх тохиолдолд Монгол Улсын эдийн засгийн өсөлт дээрх суурь төсөөллөөс доогуур гарч болзошгүй” гэлээ.

ЕСБХБ-ны Монгол дахь төлөөлөгчийн газрын дарга ноён Такаш хэлэхдээ, хувийн хэвшлийн үйл ажиллагаа сайн байгаа, улсын экспортын голлох ашигт малтмал нь ирэх оны орлогод асар их үүрэг гүйцэтгэх ба түүний борлуулалтын үнийг амжилттай тогтоож чадвал зөрүүг арилгах боломжтой, харин үнийг хэвээр нь баривал төсвийн байдал улам дордох магадлал өндөр байгааг онцлов. Мөн түүнчлэн, Оюу Толгойн далд уурхайн үйлдвэрлэлийн гарц нь 2023 онд эдийн засгийг сэргээх гол төв нь байх ба үүнд анхааралтай хандах хэрэгтэй гэлээ. Мөн тэрээр, төсвийн сахилга бат, зохицуулалт нь энэ үеийг даван туулахад их хэрэг болно гэдгийг онцолсон юм.



Ирэх оны төсөөллийн талаарх Монгол Банкны анхаарлын төвд байгаа хүчин зүйл бол шатахууны импорт ба эдийн засагт үзүүлэх голлох нөлөө болно хэмээн Санхүүгийн зах зээлийн хэлтсийн захирал О. Одгэрэл онцлов. Нефтийн бүтээгдэхүүний дийлэнхи хувь нь хойд хөршөөс төмөр замаар орж ирдэг. Манай орны хувьд гадны импортоос ихээхэн хамааралтай бөгөөд хилийн боомтын ажиллагаа, импорт, экспортын харилцаанд гарах аливаа өөрчлөлтүүд нь биднийг хямралд өртөмтгий болгож байна гэлээ.



Хэлэлцүүлгийн үеэр панелистууд статистик гол үзүүлэлтүүдийг хөндөж, одоогийн байдлаар улсын инфляцийн түвшин 14.5%-тай байна гэж мэдээлэв.

2023 оны санхүүгийн төлөв байдал, жилийн хүлээлт нь үндсэн экспортыг (эрдэс баялгийн бүтээгдэхүүн) дэмжихийн зэрэгцээ бусад боломжуудаа хөгжүүлэх, хувийн хэвшилд тулгуурласан бизнес эрхлэлтийг илүү чөлөөтэй болгох, төрийн бодлого, хуулийн хэрэгжилтийн уялдаа холбоог сайжруулах, ‘алдаагаа залруулах’ хандлагаас ихээхэн шалтгаална гэв. Хэрэв Монгол Улс ирэх жилд эдийн засгаа сэргээж, хөгжихийг хүсвэл түүнд хүрэх зам сорилттой байхыг тэмдэглэв.

АмЧам Монголын тухай

АмЧам Монгол АНУ-Монгол Улс хоорондын бизнесийн түншлэлийг өргөжүүлэх, бэхжүүлэх, эрх ашгийг нь хамгаалах болон Америкийн хөрөнгө оруулалтыг Монголд татах чиглэлээр ажилладаг бие даасан, гишүүддээ үйлчлэх төрийн бус байгууллага юм. АмЧам Монгол 3 сая гаруй гишүүдтэй дэлхийн хамгийн том бизнесийн холбоонд тооцогддог Америкийн Худалдааны Танхимын албан ёсны салбар юм. Мөн Ази Номхон далайн 29 орны Америкийн худалдааны танхимуудыг нэгтгэдэг Ази Номхон далайн орнуудын Америкийн Худалдааны Танхимуудын Зөвлөл байгууллагын гишүүн юм.